



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/84

Алтлага

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн эзэмшил болон өвөлжөө, хаваржааны зориулалтаар (3 иргэн 30000м2) эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул хүсэлтийн дагуу хавсралтаар хугацааг сунгаж эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын захирамжийн хавсралтын холбогдох заалтуудыг хүчингүй болгосугай.

3.Захирамжаар газар эзэмшигч иргэдийн газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (Д.Батсайхан)-д зөвшөөрсүгэй.

4.Сумын Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010192